



**МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН
ҮНДЭСНИЙ ПАРКЫН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2021 оны 10 сарын 11 өдөр

Дугаар 1А-044

Улаанбаатар хот

Инкубаторын 42 дахь элсэлтийг зохион байгуулж,
сонгон шалгаруулах ажлын хэсэг томилох тухай,

“Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, “Мэдээллийн технологийн инкубаторын үйл ажиллагааны журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.7 дахь хэсэг, “Мэдээллийн технологийн инкубаторын, “Инкубаторт компани, иргэнийг сонгон шалгаруулж элсүүлэх, үйл ажиллагаанд нь хяналт шинжилгээ хийж, үнэлгээ өгөх ажлын хэсэг байгуулах журам”-ын 5.1, 5.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Мэдээлэл, технологийн инкубаторын 42 дахь элсэлтийг зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар, шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Инкубаторын 42 дахь элсэлтийг зохион байгуулах ажлыг 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөрт багтаан зохион байгуулж, үр дүнг танилцуулахыг Төслийн удирдлага, сургалт, маркетингийн хэлтсийн дарга /П.Наранцэцэг/-д даалгасугай.

3. Энэхүү сонгон шалгаруулалтад шаардагдах 441,500 /дөрвөн зуун дөчин нэгэн мянга таван зуу/ төгрөгийг зохих журмын дагуу гаргахыг нягтлан бодогч /Д.Цэрэндолгор/-д зөвшөөрсүгэй.

ЗАХИРАЛ



Э.ЦОГТГЭРЭЛ